



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-10

1.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	6-9
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/	9-10

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
11 дүгээр сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 21 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Жаргалсайхан, Ж.Чинбүрэн;

Чөлөөтэй: Н.Алтаншагай, С.Амарсайхан, О.Амгаланбаатар, П.Батчимэг, З.Мэндсайхан, У.Отгонбаяр, Ц.Туваан.

Нэг.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Үндэсний статистикийн хорооны Эдийн засгийн статистикийн газрын Хөдөө аж ахуй, байгаль орчин, үйлдвэрлэлийн статистикийн хэлтсийн дарга Э.Мягмарханд, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, мөн хэлтсийн мэргэжилтэн Б.Гарамханд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Үндэсний давхар даатгалын компанийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

М.Ганхүлэг: Төслийн 1 дүгээр зүйл буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан статистикийн мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	8
Бүгд:	17

52.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

М.Ганхүлэг: Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	7
Бүгд:	17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхайн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат хариулж, тайлбар хийв.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

М.Ганхүлэг: Төслийн 3 дугаар зүйлийн “хуулийн” гэсний дараа “7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “зургаан” гэснийг “таван” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	7
Бүгд:	17

58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл санал хэлэв.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

М.Ганхүлэг: Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

М.Ганхүлэг: Төсөлд доор дурдсан агуулгатай зүйл нэмэх:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн:

Хоёр.Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

М.Ганхүлэг: 1.Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтөгтох нар байлцав.

Хуралдаан даргалагч М.Ганхүлэг “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

М.Ганхүлэг: “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 7

Бүгд: 17

58.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарыг оруулахаар тогтов.

Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяаг дэмжсэнээр тооцож, 66.7 хувиар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 46 минут үргэлжилж, 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 15 цаг 45 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

М.Ганхүлэг: Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн тул хуралдааныг эхлүүлэе. Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа.

Байнгын хорооны гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж, ирц 53.3 хувьтай бүрдсэн тул БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдааны нээснийг мэдэгдэж байна аа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүдийн сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна аа. Хуралдаанд Жигжидийн Батжаргал гишүүн, Сонгобайн Замира, Сүрэнжавын Лүндэг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Нанзадын Наранбаатар, Болдын Уянга, Мөнгөнцогийн Ганхүлэг, Жаргалсайханы Золжаргал, Мэндбаярын Мандухай, Тогтмолын Мөнхсайхан, Ренчинбямбын Сэддорж, Гонгорын Дамдинням, Цагаанхүүгийн Идэрбат, Цагаанхүүгийн Мөнхбат, Баатаржавын Мөнхсоёл, Агваанлуvsангийн Ундраа гишүүд хүрэлцэн ирсэн байна аа.

Хэлэлцэх асуудал. Өнөөдөр 2 асуудал хэлэлцэхээр байгаа.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл ЗГ-ын 2025 оны 1 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг явагдаж байна.

2.Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё оо. [Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.](#)

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Ажлын хэсгийг бас оруулаарай. Сангийн яамнаас Жавхлан сайд орж ирэх ёстой юм байна. Жавхлан сайдыг дуудаарай. Эс үгүй бол төлөөлж байгаа хүмүүс нь ямар хүн байна. Сангийн яамнаас байгаа юм уу? Тийм Амарбаясгалан төлөөлөл нь байна уу тэ?

Үндэсний статистикийн хорооноос Мягмарханд Эдийн ЗГ-ын Үндэсний Статистикийн хэлтсийн дарга. Манайхан босоод. Мягмарханд байна уу? Сангийн яам Б.Амарбаясгалан Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл, олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Б.Гарамханд Санхүүгийн бодлогын газрын Санхүүгийн зах зээл олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас Ц.Болорчулуун Бодлого төлөвлөлтийн газрын дарга хүрэлцэн ирсэн байна. Үндэсний давхар даатгалын компанийн гүйцэтгэх захирал Б.Жавхлант хүрэлцэн ирсэн байна. Шинэзул эрсдэлийн удирдлагын ахлах ажилтан. Мягмарханд уу? Мягмарханд орж ирсэн байна.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг Байнгын хорооноос байгуулагдан ажилласан байгаа. Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна аа.

М.Ганхүлэг: Байнгын хорооны хуралдаан даргалагч болон эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл болон уг хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 1 сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н байнгын хороонд шилжүүлсэн. Уг хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2025 оны 6 тоот тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Идэрбат, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Ганбаатар, Р.Сэддорж, У.Отгонбаяр нарын гишүүд ажиллалаа. Ажлын хэсэг энэ хугацаанд нийт 6 удаа хуралдаж хууль санаачлагч болон хуулийн төслийг боловсруулахад оролцсон ажлын хэсгээс холбогдох тодруулгуудыг авсан болно оо.

Ажлын хэсэг дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж та бүхэнд танилцуулж байна аа.

Үүнд:

Даатгагч гэрээний хугацаанд ус, цаг уур, орчны шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан сумын малын хорогдлын дүнд үндэслэн нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болох, даатгалын тохиолдлыг тодорхойлох, эрсдэлийг хуваарилах зорилгоор сум бүрээр тогтоосон 1 дүгээр босго үзүүлэлтийг 5 хувь, 2 дугаар босго үзүүлэлтийг 30 хувь байхаар тогтоож, Засгийн газар босго үзүүлэлтийг шинэчлэн тогтоохдоо 1 дүгээр босго үзүүлэлтийг нэг хувиар, 2 дугаар босго үзүүлэлтийг 5 хүртэл хувиар нэмэгдүүлж эсвэл бууруулж тогтоож болох хуулийг 2026 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх, Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах зарчмын саналуудыг гаргалаа. Ажлын хэсгээс бэлтгэсэн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд. Баярлалаа.

М.Ганхүлэг: Цагаанхүүгийн Идэрбат гишүүнд баярлалаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцье.

Гишүүд та бүхэнд тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асуух болон зарчмын зөрөөтэй санал гаргаж болно оо.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Ингээд зүйл бүрээр нь та бүгдээс асуугаад ингээд явах юм байна.

1 дүгээр зүйлтэй холбогдолтой асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс санал ирүүлсэн байгаа. 1 санал байгаа.

Төслийн 1 дүгээр зүйл буюу 12.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.4.Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан урьдчилсан мэдээ, Статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын энэ хуулийн 6.1-д заасан хугацаанаас өмнө гаргасан статистикийн мэдээллийг үндэслэн даатгагч энэ хуулийн 4.1.8-д заасан гэрээний хугацаанд нөхөн төлбөрийг нэг удаа урьдчилан олгож болно.”

Энэ асуудалтай холбогдолтой санал хураалтууд явагдана. Гишүүд танхимдаа орж ирэхийг хүсье. Нэгдсэн байдлаар санал хураалтыг явуулж болно.

Гишүүдийг манайхан оруулж ирээрэй. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдолтой Идэрбат гишүүн тайлбар хэлье. Идэрбат гишүүний микрофоныг.

Ц.Идэрбат: Бид ЗГ-ын өргөн барьсан Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн ажлын хэсгийг ахалж ажилласан. Тэгээд бид хэд бас нөгөө холбогдох хуулийнхаа дагуу бол зөвхөн ЗГ-ын өргөн барьсан хөндсөн зүйл заалтын дагуу бид асуудлыг бас хүрээ маань тийм хязгаарлалттай. Гэхдээ энэ дээр 12.4 дээр бол Засгийн газрын өргөн барьсан төсөл дээр бол яах вэ агуулгын хувьд бол урьдчилж нэг удаа олгоно гэсэн ийм үндсэн агуулгатай. Гэхдээ үүн дээрээ статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэсэн ийм үг байсан. Байгууллагын нэр цохогдсон. Түүн дээр нь ажлын хэсгийн зүгээс ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагынхыг гэж нэмж бас оруулж байгаа юм. Тэгэхээр энэ бол хөндөгдсөн заалт. Дээр нь нэг байгууллагыг дээр нь нэмж өгч байгаа юм аа л гэж ойлгож болно.

М.Ганхүлэг: Гишүүд санал хураалтдаа бэлдье.

Санал хураалт. 9 гишүүн 52.9 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Мандухай гишүүн хүнээр тасаллаа. Мандхай гишүүн.

М.Мандхай: Одоо хэрэгжиж байгаа хуулийн 7.2 дээр энэ нөгөө босго үзүүлэлтийг тогтоох гэсэн заалт дотор яг 7.2 бол өөрөө 6 хувь, 2 дугаар босго нь 30 хувь гэсэн байгаа. Тэгээд энийг 5 болгож өөрчилж байгаа. Энэ дээр нэг тайлбар авъя аа.

М.Ганхүлэг: Ажлын хэсгийн ахлагч Идэрбат гишүүний микрофоныг өгье.

Ц.Идэрбат: Энэ малын индексжүүлсэн даатгалын хууль маань өөрөө 2014 оноос хойш хэрэгжиж эхэлсэн. Ер нь бол бүүр түүхийг нь яривал 2009 онд жишээ нь Дэлхийн банкны санхүүжилтээр төсөл хэрэгжээд 5 жил явж байгаад 2014 онд энэ хууль маань батлагдаад ингээд явсан. Тэгээд энэ хууль анх батлагдахдаа энэ индексжүүлсэн хувийг тогтоохдоо улс орон даяар ингээд 6 хувь гээд ингээд тогтоосон байдаг. Ингээд 2024 онд энэ Монгол Улсын Засгийн газар, Сангийн яамнаас энэ хуулийн төслийг өргөн барихынхаа өмнө малчидтай бас нэлээдгүй уулзалтууд хийсэн юм байна лээ. Тэндээс гарч байгаа малчдын санал бол энэ 6 хувь гэдгийг бууруулмаар байна, 1 дүгээрт.

Хоёрдугаарт бол бас улс даяар биш сум болгоноор болгоё оо гэдэг нэг ийм зүйлүүд яригдсан. Тэгээд Засгийн газраас энэ 6 хувийг өөрчлөхдөө ер нь уян хатан тогтооно оо гэсэн ийм хуулийн төслийг өргөн барихдаа ийм агуулгатай зүйл заалт өргөн барьсан. Ажлын хэсгийн хувьд хуралдаад бид малчдын ер нь амьдрал дээр ч тэр энэ даатгалын тогтолцоо бас олигтой хөгжихгүй байгаа. Тогтворжихгүй байгаагийн шалтгаан бол бас энэ 6 хувийн босго юм аа.

Тэр нь ч бас малчдын саналаар баталгаажсан байна. Тийм учраас энэ хуулийг хэрвээ бид ингээд баталгаа хүрэх юм бол бас 6 хувь гэдэг нь максимумдаа байя. Тэрнээс доош нь байлгая гэдэг ийм чиглэлийг бас ярилцаад тэгээд одоо манай дэд ажлын хэсэгтэйгээ бас бид 3, 4 удаагийн хурлууд хийж байгаад энэ 6 хувийг 5 хувь болгож бууруулаад. Гэхдээ энэний чинь цаана бас нөгөө нэг санхүүгийн харилцаанууд үүснэ. Төр болон хувийн хэвшлийн даатгалын компаниудын хоорондын харилцан хамааралтай олон ажлууд байгаа.

Тийм учраас 5-ыг бол нэмж хасах нэг хувь гэж уян хатан болгож оруулъя аа. Тэгэхээр яах вэ одоо байгаа судалгаагаар харахад бол Монгол Улсад 330 сумын маань 160-аад нь 4 хувь руугаа орно. 130-аад нь юу руугаа орно, 5 хувь руугаа орно.

59, 60 сум нь 6 хувьтай байх ийм байгаа юм. Тэгэхээр ажлын хэсгийн зүгээс бол хөндөгдсөн заалт. Хөндөгдсөн заалтыг өшөө тодорхой болгохын хүрээнд дэд ажлын хэсэгтэйгээ хамтарч ажиллаж байгаад энэ 5 хувь гэдэг энэ зүйлийг оруулж ирж байгаа гэж ойлгож болно. Баярлалаа.

М.Ганхүлэг: Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан санал хураалтыг эхлүүлье. Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 7.2 дахь хэсгийг хасах гэсэн энэхүү заалтыг санал хураалт эхлүүлье.

10 гишүүн 58.8 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Сая 2-ыг ярьсан. Одоо 3 дахь нь алга байна. Ажлын хэсгээс ирүүлсэн нэг санал байгаа түүнийг би бас уншиж өгье.

Төслийн 3 дугаар зүйлийн хуулийн гэсний дараа 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг “6” гэснийг “5” гэж нэмэх талаар санал оруулж ирсэн байна. Сая ерөнхий тайлбар хэлчихсэн дээ. Саяын тайлбарласан.

Санал хураалт.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхсоёл гишүүн. Мөнхсоёл гишүүнээр тасалъя.

Мөнхсоёл гишүүний микрофоны өгөөрэй.

Б.Мөнхсоёл: 4 дээр төслийн 5 дугаар зүйлийг хасах гээд. Гэтэл 5 дугаар зүйлийг харахаар малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаанд баримтлах зарчим нь байгаа байхгүй юу. Тухайлбал сайн дурын үндсэн дээр даатгалд хамрагдах, малыг тухайн мал тоологдсон сумын нутаг дэвсгэрт даатгуулах, төрлийг нь даатгуулах гэх мэт байна шүү дээ. Баримтлах зарчимгүй бол яаж даатгуулах билээ. Энэ дээр асуулт асууя. Асуултаа больсон уу? Ойлголоо.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асуулаа. Санал хураалтыг явуулъя.

Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналаар санал хураая.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүд байвал нэрээ өгье.

Алга байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйл.

Төсөл доор дурдсан агуулгатай зүйлийг нэмэх:

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн агуулгыг нэмэх.

Санал хураалтыг эхлүүлье.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамт өргөн мэдүүлсэн, Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Ажлын хэсгээс санал ирүүлсэн байгаа. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томъёолол.

1.Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн ийм санал орж ирж байгаа юм байна.

Санал хураалтыг явуулъя.

58.8 хувиар санал дэмжигдлээ.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Малчны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаар Байгаль орчин, хүнс, байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганд Ц.Идэрбат гишүүн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

12.44 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Байнгын хорооны тогтоолын төсөл. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал байгаа.

Тогтоолын төслийг та бүхэндээ уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн БОХХАА-н байнгын хорооноос тогтоох нь:

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн энэ төслийг байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийг чөлөөлж, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатарыг нэмсүгэй.

БОХХАА-н байнгын хорооны дарга Бейсен гэсэн Байнгын хорооны тогтоол байна аа.

Тогтоолын төсөлтэй холбогдолтой асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна.

Санал хураалтыг явуулъя.

Тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалтыг явуулъя.

Санал хураалт.

Гишүүд санал хураалтдаа эхлээд бэлдэх юм байна.

Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя аа.

Санал хураалт.

58.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.

Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэндээ баярлалаа. Мөн маргааш болох Улс тунхагласны баярын мэндийг бас гишүүддээ болон нийт иргэддээ бас дэвшүүлье ээ.

17.46 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

й